

Академч Л. Лигети ба дундад үеийн монгол хэлний судлал*

Д. Төмөртоогоо (МУИС)

Монгол хэлний хөгжилийн түүхийг цуваа цагийн үүднээс нэхэн судлахад эртний бичигийн дурасхалууд гол чухал баримт материал болдог билээ. Эдүгээ бидний үед уламжилан үлдсэн бичгийн дурасхалууд нь XIII-XV зууны үед монгол, хятад, дөрвөлжин, араб үсэгээр тэмдэглэгдсэн бөгөөд хэлнийхээ шинжээр IX-X зууны үеэс аваад XIV-XV зууны үеийг хүртэлхи 6-7 зуун жилийн онцлог шинжийг хадгалан үлджээ. Монгол хэлний бичгийн дурасхалуудыг бүр XIX зууны эхнээс аваад олон ороны эрдэмтэд сонирхон судалсаар ирсэн билээ.

Монгол хэлний бичгийн дурасхалын судлалд томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэн бол өнөөдөр бид 100 жилийнх нь ойг ёслон тэмдэглэж байгаа мажаарын нэрт монголч эрдэмтэн Лайош Лигети билээ. Тэрвээр монгол хэлний хөгжилийн түүхийн өөр өөр үеийн онцлог шинжийг тусхасан монгол, хятад, дөрвөлжин, араб бичгийн дурасхалуудыг олон жилийн турш нягтлан судалсан байна.

Бид энд түүний бүтээлүүдийн дотороос дундад үеийн монгол хэлэнд холбогдох судалгааны тухай тусхайлан ярих учир түүнд шууд холбогдох гурван өөр төрөл бичгийн дурасхалын судалгааны тухай товч дурдая.

1. **Хятад үсгийн дурасхал.** Дундад үеийн монгол хэлний онцлогийг тусхасан хамагийн том дурасхал болох "Монголын Нууц Товчоо"-г нэрт монголч E. Haenisch¹, С.А. Козин², К. Ширатори³, П. Пелльо⁴ нар анх уншиж галигласан бөгөөд дараа нь түүний бүрэн эхийг акад. Л. Лигети шинэчлэн галиглаж 1964 онд нийтлүүлжээ⁵. Тэрвээр хожим 1971 онд уул бүтээлээ хянан засварлаад дахин нийтлүүлсэн⁶ бөгөөд түүнийг олонхи эрдэмтэд хамагийн зөв уншилт гэж хүлээн зөвшөөрдөг билээ. Акад. Л. Лигети энэхүү судалгаандаа нэг талаас хятад ханз үсгийн эртний дуудлага, нөгөө талаас, дундад үеийн монгол хэлний авианы онцлог хоёрыг оновчтойгоор оноон тогтоосон нь монгол түүхэн судлалд үлгэр дууриал болсоор ирлээ.

* 2002 оны 5-р сарын 10-ны өдөр академич Л. Лигетийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд тависан илэдхэл.

¹ E. Haenisch, *Manghol-un Niuca Tobca'an* (Yüan-ch'ao-pi-shi) Die Geheime Geschichte der Mongolen, aus der chin. Transkription im mongolischen Wortlaut wiederhergestellt, Leipzig, 1937, 140 S.

² С. А. Козин, *Сокровенное сказание*. Монгольская хроника 1240 г. под названием *Monggol-un Niyuča Tobčayan*, т. I, М.-Л., 1941, 619 стр.

³ P. Pelliot, *Histoire secrète des Mongols*, Restitution du texte mongol et traduction française des chapitres I-VI, Librairie d'Amérique et d'Orient, Adrien-Maisonneuve, Paris, 1949, 120 p.

⁴ K. Shiratori, *Onyaku-Mōhun-Genchō-Hishi*. A Romanised Representation of the *Yüan-Ch'ao-Pi-Shi* in its Original Mongolian Sound Tōyō Bunko Publications, Series C, Tokyo, 1942.

⁵ L. Ligeti, *A mongolok titkos története*, Mongol Nyelvelméletár, III, Budapest, 1964.

⁶ L. Ligeti, *Histoire secrète des Mongols* [=Monumenta Linguae Mongolicae Collecta I], Budapest, 1971, 268 p.

Тийм ч учираас Игор де Рахевилц⁷, Хитоши Курибаяши⁸ нар түүний энэхүү судалгаан дээр үндэслэн өөрсдийн шинэ судалгааг гаргасан билээ. Мөн түүнчилэн Юан гүрэний үед зохиогдсон *Tche-yuan yi-yu* хэмээх 540 гаруй үг бүхий хятад-монгол зүйл хуваасан толийг галиглан буулгасныг хожим профессор, поктор Г. Кара нийтлүүлжээ⁹.

2. Дөрвөлжин үсэгийн дурасхал. Дундад үеийн монгол хэлний онцлог шинжийг тэмдэглэсэн хоёрдох чухал дурасхал нь дөрвөлжин үсэгийн дурасхалууд билээ. Акад. Л. Лигети бүр 1942 онд дөрвөлжин үсэгийн дурасхалын тухай анхны ажилглалтаа нийтлүүлжээ¹⁰. Тэрвээр хожим "*Дөрвөлжин үсэгийн тухай гурван тэмдэглэл*"¹¹ гэдэг үгүүлэлдээ үгийн эхний титэмтэй эгшиг, үгийн дунд орсон *ö* эгшигийн өвөрмөц бичлэг хийгээд сугарсан гийгүүлэгчийн байранд үлдсэн амисхалын түрэлтийн тухай сонирхолтой ажиглалт дүгнэлтүүд хийсэн байна.

Мөн "*Монгол дөрвөлжин үсэгээр тэмдэглэсэн Субашидын тасархай*"¹² хэмээх томоохог бүтээлдээ Турфанаас олдсон дөрвөлжин үсэгийн Субашидын гурван хэсэг тасархай хэсэгийг үсэгийн болон авианы галигаар нарийвчлан буулгаж, бүх үгсийн жагсаалт болон зарим үгсийн тайлбарыг хавсаргажээ. Мөн уул дурасхалын урагдаж тасараад, уншигдахгүй болсон үгсийг монгол Субашидын бүрэн эхтэй харьцуулан үзээд, сэргээн уншсан нь эх бичгийн судлал төдийгүй, дундад үеийн монгол хэлний судлалд чухал хувь нэмэр болжээ.

Түүнчилэн үгийн эхний *h-*, *q-* гийгүүлэгчид болон хоёр эгшигийн хоорондоос сугарсан *-γ-* (*-g-*)-гийн тухай тусхайлан дурдсан нь дөрвөлжин үсэгийн бичлэгийн дүрэм хийгээд дундад үеийн монгол хэлний гийгүүлэгч авианы онцлогийн талаар дурдсан сонирхолтой ажиглалт билээ¹³.

Монгол дөрвөлжин үсэгийн дурасхалуудыг анх М. Левицкий¹⁴, Н. Поппе¹⁵ нар анх түүрү эмхэдхэн гаргасан бөгөөд хожим акад. Л. Лигети дөрвөлжин бичигийн хорь гаруй дурасхалыг багтаасан тусхай эмхэдхэл гаргасан нь тухайн үедээ хамагийн олон дурасхалыг хамарсан бүтээл болсон билээ¹⁶.

3. Араб үсэгийн дурасхал. XIV-XV зууны монгол хэл аялгууг араб үсэгээр тэмдэглэсэн арав орчим дурасхал эдүгээ уламжилан үлдсэн бөгөөд тэдгээрийн дотороос Лейден хотын номын сан дахь монгол-перс гар бичмэл толь, Хамдуллаха Казвиний зохиосон гурван хэлний толинд орсон монгол үгс, Мукаддимат ал-Адаб толийн монгол хадмал орчуулга, Ибн Муханны толинд орсон монгол үг зэрэг дурасхалын талаар П. М. Мелиоранский¹⁷, Н. Поппе¹⁸, П. Пелльо¹⁹

⁷ Igor de Rachewiltz, Index to the Secret of the Mongols [=Uralic and Altaic Series 121], Bloomington, Indiana, 1972, 343 pp.

⁸ H. Kuribayashi, Chojinjab, Word and Suffix-Index to the Secret History of the Mongols. Based on the Romanized Transcription of L. Ligeti [=Center for Northeast Asian Studies Monograph Series №4], Tohoku University, Sendai, 2001, 954 pp.

⁹ L. Ligeti, Un vocabulaire sino-mongol des Yuan. Le Tche-yuan yi-yu, Acta Orientalia Hungarica 44, 1990, pp. 259-277.

¹⁰ L. Ligeti, A 'Phags-pa irásos nyelvelékek, Melich-Emlékönyv, Budapest, 1942, pp. 222-237.

¹¹ L. Ligeti, Trois notes sur l'écriture 'Phags-pa, Acta Orientalia Hungarica 13, 1961, pp. 201-237.

¹² L. Ligeti, Les fragments du *Subhāsitaratnanidhi* mongol en écriture 'phags-pa. Mongol préclassique et moyen mongol, Acta Orientalia Hungarica 17, 1964, pp. 239-292.

¹³ L. Ligeti, Les fragments du *Subhāsitaratnanidhi*, pp. 282-291.

¹⁴ M. Lewicki, Les inscriptions mongoles inédites en écriture carrée, *Collectanea Orientalia*, XII, Wilno, 1937, pp. 1-72.

¹⁵ N. Poppe, The Mongolian Monuments in 'Pags-pa Script [=Göttinger Asiatische Forschungen 8], Wiesbaden, 1957, pp. 1-147.

¹⁶ L. Ligeti, 'Phags-pa irásos emlékek. Kancelláriai iratok kinai átírásban, Mongol Nyelveléktár, II, Budapest, 1964; Monuments en écriture 'phags-pa [=Monumenta Linguae Mongolicae Collecta III], Budapest, 1972, pp. 9-127.

¹⁷ П.М. Мелоранский, Араб филолог о монгольском языке СПб., 1903, стр. 171.

¹⁸ N. Poppe, Das mongolische Sprachmaterial einer Leidener Handschrift, - *Bull. de l'acad. Des Sc. de l'URSS*, 1927 (pp. 1009-1040, 1251-1274); Монгольские названия животных в труде Хамдуллаха Казвини, Записки Коллегии востоковедов, т. 1, 1925, стр. 195-208; Монгольский словарь Мукаддимат ал-Адаб [=Труды Института Востоковедения 14], ч. I-II, М.-Л., 1938, 93-393, 432-451.

¹⁹ P. Pelliot, Les formes turques et mongoles dans la nomenclature zoologique du Nughati-'l-kulub, - *Bulletin of the School of Oriental Studies* 6, 1931, pp. 555-580.

нар анхлан судалсан билээ. Проф. Л. Лигети өнгөрсөн зууны жараад онд Истанбулын номын санд хадгалагдаж байсан "Шамил үл-луга" хэмээх толийн хавсралтанд орсон монгол үгсийг анх олж судалсан нь араб үсэгийн монгол дурасхалуудын судалгаа төдийгүй, дундад үеийн монгол хэлний түүхэн судлалд чухал хувь нэмэр болсон билээ.

Тэрвээр энд 400 гаруй монгол үгийг галиглан буулгаад хятад, араб үсэгээр тэмдэглэсэн бусад дурасхалуудын зохих үгстэй харьцуулан үзсэн нь дундад үеийн монгол хэлний судлалд ихээхэн ач холбогдолтой судалгаа болжээ²⁰. Акад. Л. Лигети "Стамбулын монгол толийн тухай тэмдэглэл" гэсэн дараачийн судалгаандаа араб бичигийн *kasra*, *ya* үсэгээр тэмдэглэсэн *i*, *e* эгшиг, *fatha* үсэгээр тэмдэглэсэн *a*, *ā* эгшиг, *wāw*, *damma* үсэгээр тэмдэглэсэн уруулын *u*, *ū* эгшигүүд болон үгийн эхний шүргэх *h*-гийн тухай дурдаад уламаар урт эгшиг, хос эгшиг, эгшигийн ижилшилийн талаар тодорхой жишээтэйгээр тайлбарлажээ²¹.

Хожим 1970-аад оны дундаас "Расулидын зургаан хэлний толь"²²-ийг хамтаран судлах олон улсын эрдэмтдийн багийн бүрэлдэхүүнд орж, монгол үгсийн хэсэгийг уншин судлах ажилыг амжилттай гүйцэтгэж байгаад, хараахан дуусхаж амжилгүй таалал төгөсчээ.

Акад. Л. Лигетийн "Лийчийн монгол толь"²³, "Могол хэлний урт эгшиг"²⁴, "Ганжакийн Кирагосын монгол толь"²⁵ зэрэг судалгаанууд нь могол хэлний авиазүй, үгийн сангийн судлал төдийгүй дундад үеийн монгол хэлний бичигийн дурасхалуудын харьцуулсан судлалд чухал хувь нэмэр болсон билээ.

Л. Лигетийн судалгааны өөр нэгэн сонирхолтой тал бол монгол-түрэг, монгол-манж хэлний хамааралын асуудал болон эртний монгол хэлний тухай асуудал юм. Үүнтэй холбогдуулан "Алтайн хэл ба үгсийн сангийн тооцоолон бодох арга"²⁶, "Манж хэлэндэх эртний монгол элемент"²⁷, "Сяньби хэлний табгач аялгуу"²⁸ зэрэг бүтээлийг дурдаж болно.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, акад. Л. Лигети орчин цагийн монгол хэл аялгуунаас эхлээд дундад үеийн монгол хэл, эртний монгол хэлний онцлогийг тусхасан бичигийн дурасхалууд, монголчуудын дээд өвөг болох сяньбичуудын хэл аялгуу, мөн түүнчилэн монгол-түрэг, монгол-манж хэлний нийтлэг шинжийн тухай үлэмж өргөн хүрээтэй судалгааг хэлшинжилэлийн онолын өндөр төвшинд хийжээ. Түүний судалгааны бүтээлүүд нь монгол хэлний түүхийн судлалд үнэлж барашгүй хувь нэмэр болсоор ирсэн, хойшид ч судалгааны үнэ цэнээ хэзээ ч алдахгүй мөнхийн бүтээл болжээ.

²⁰ L. Ligeti, Un vocabulaire mongol d'Istanbul, *Acta Orientalia Hungarica* 14, 1962, pp. 3-99.

²¹ L. Ligeti, Notes sur le vocabulaire mongol d'Istanbul, *Acta Orientalia Hungarica* 16, 1963, pp. 107-174.

²² Peter B. Golden, *The King's Dictionary. The Rasulid Hexaglot: Fourteenth Century Vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian and Mongol*, Brill. Leiden /Boston/ Köln, 2000, I-XII+1-418+22 Tables.

²³ L. Ligeti, Le lexique moghol de R. Leech, *Acta Orientalia Hungarica* 4:1-3, 1954, 119-157.

²⁴ L. Ligeti, Les voyelles longues en moghol, *Acta Orientalia Hungarica* 17:1, 1964, pp. 1-48.

²⁵ L. Ligeti, Le lexique mongol de Kirakos de Gandzak, *Acta Orientalia Hungarica* 18, 1965, pp. 241-297.

²⁶ Л. Лигети, Алтайская теория и лексикостатистика, *Вопросы Языкознания* 3, 1972, pp. 21-33.

²⁷ L. Ligeti, Les anciens éléments mongols dans le Mandchou, *Acta Orientalia Hungarica* 10:3, 1960, pp. 231-248.

²⁸ L. Ligeti, Le tabghatch, un dialecte de langue sien-pi, *Mongolian Studies*, Budapest, 1970, pp. 265-308.

